

ТӨВДИЙН ТӨМӨР ЗАМ

Ш.ДОГМИЙЧОЙДОН*

БНХАУ-ын Хөхнуур мужийн Голмуд хотоос Төвдийн Өөртөө Засах Орны Лхас хот хүртэл далайн түвшнээс дээш хамгийн өндөрт орших төмөр замыг 2005 оны 10-р сард тавьж дуусгав. Ийнхүү Хятад дахь төмөр замгүй цорын ганц муж болох Төвдөд дэлхий дээр хамгийн өндөрт орших төмөр байгуулагдав. Үүнээс урьд Төвд рүү хүргэх тээвэрлэлтийн 90 гаруй хувийг засмал замаар хүргэдэг байсан аж.

Уг төмөр замын бүтээн байгуулалт Хятадын Засгийн газраас батласан 10-р таван жилийн төлөвлөгөө “Баруун бүс нутгийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-нд багтан орсноор дотоод, гадаадын эсэргүүцэлтэй олон тулгарч байсан бөгөөд хамгийн гол нь Төвдөд баруун бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө хэмээх нэрийн дор Төвдийн ӨЗО-ы нутагт хятад үндэстнийг олноор нүүлгэн суурьшуулах, зүүн далайн эрэг хавийн бүс нутгийн хэрэгцээт ургамлын тос, модны нүүрс зэрэг хэрэгцээг хангах, байгалийн баялгийг ашиглах гэсэн бодлого хэмээн үзэх нь цөөнгүй байв. Хэдийгээр Төвдөд төмөр зам тавих ажил ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч байсан ч уг байгууламж ашиглалтанд орсноор Төвд рүү хүргэх тээврийн зардал багасч эдийн засгийн өсөлт хөгжилтөд томоохон түлхэц болохын сацуу Төвдийн өвөрмөц онцлогтой бараа бүтээгдэхүүнийг Хятад даяар, цаашилбал гадаадын зах зээлд гаргах гарц болж чадна хэмээн нөгөө хэсэг нь үздэг байна.

Энэхүү төмөр замын бүтээн байгуулалтын анхан шатны ажлыг 1958 онд эхлүүлж 1984 онд дууссан бөгөөд БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Баруун бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгагдсанаар хоёр дахь шатны ажлыг 2001 оноос эхэлжээ. Уг төмөр замын 960 гаруй км нь далайн түвшнээс дээш 4000 метрийн өндөрт баригдсан бөгөөд 550 орчим км нь мөнхийн цэвдэг газраар дайран өнгөрч 30 орчим төмөр замын өртөө, 26.2 тэрбум юань буюу 4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт

хийж, 2007 онд ашиглалтанд оруулахаар анх тооцоолж байв. Гэвч ийм хэт өндөрт төмөр зам тавих боломжгүй бөгөөд хэрэв барьж чадвал инженерийн түүхэн дэх нэгэн гайхамшиг болно хэмээн ярьж бичиж байв.

Ийнхүү ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч байсан ч уг төмөр замын байгууламжийг нэгэнт барьсан бөгөөд нэн өндөрт төмөр зам баригдаж буйгаас агаарын даралт хэт сийрэг байдаг учир нуруундаа хүчилтөрөгчийн савтай 38000 гаруй ажилчин уг төмөр замыг барьсан хийгээд үүн дотор 3 км гаруй урт хоолой, 12 км орчим урт гүүрийг барьж байгуулжээ.

Мэргэжилтнүүдийн үзэж буйгаар энэ зам нь Төвдийн засаг захиргааны төв Лхас хотыг хөрш Хөхнуур мужтай холбон нийт Хятадын төмөр замын сүлжээг өргөжүүлэхийн зэрэгцээ Төвдийн эдийн засгийн хөгжлийг шинэ эрин үед авчрах зам хэмээж буй.

Синьхуа агентлагийн мэдээлснээр, уг төмөр замаар Төвд рүү ачаа тээвэрлэлтийг агаарын ба хурдны замаас хамгийн хямд зардлаар хүргэх боломжтой аж. Урьдчилсан тооцоогоор 1 сая гаруй жуулчин, 2.5 сая тонн ачааг энэхүү төмөр замаар нэг жилд л тээвэрлэх хүчин чадалтай юм байна.

БНХАУ-ын Засгийн газраас баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн хүрээнд Төвдөд хэрэгжүүлж буй хамгийн том хөтөлбөр болохын хувьд уг төмөр замын байгууламжийг “Зууны бүтээн байгуулалт”, “Баруун бүс нутгийг хөгжлүүлэх стратегийн билэг тэмдэг” хэмээн нэрлэж байна. Уг зам нь одоогоор туршилтын тээвэрлэлт хийж буй бөгөөд 2007 оноос хүн тээвэрлэлт хийж эхлэх аж.

БНХАУ-ын ТӨЗО-ы засгийн ордны дэд тэргүүлэгч Түвдэнцэвээн бээр “Баяжъя гэвэл зам зас” хэмээн нэгэнтээ хуучны үгийг иш татсанчилан энэхүү зам нь Төвдийн Өөртөө Засах Орны баяжин дээшлэхийн зам байх нь дамжиггүй.

* Ш.Догмийчойдон. ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан